



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2017 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 65

Номгон

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.11 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянлиг сумын уурын зуухны барилгын хувьчлал, Эрүүл мэндийн төвийн доторх орон сууц, дуудлага худалдаагаар иргэн Р.Даваагийн худалдан авсан сургуулийн хичээлийн байрны барилга, сургуулийн 4 айлын орон сууц, халуун усны барилгын үнийн дутуу төлөлт, сумын Засаг даргын албан тушаалын автомашин, Санхүүгийн хяналт, аудитын албанаас эмийн эргэлтийн санд тавьсан актаар тогтоогдсон төлбөрийг холбогдох хүмүүсээр төлүүлэх талаар газар дээр нь үзэж, үнэлэлт, дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Мөнхбат-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

Гишүүд: С.Амармөнх-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Ч.Мөнхцэцэг-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

Л.Доржханд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

Ц.Байгальмаа-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын

Тэргүүлэгчдийн ажлын албаны ахлах мэргэжилтэн

2. Ажлын хэсгийн дүгнэлтийг 2017 оны 05 дугаар сарын 01-ний дотор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд хэлэлцүүлэхийг ажлын хэсэг /М.Мөнхбат/-т даалгасугай.

ДАРГА Ц.ОТГОНБАЯР

0117009